

ОРОСЫН ШУА-ИЙН СИБИРИЙН САЛБАРЫН МОНГОЛ, БУДДЫН ШАШИН, ТӨВӨД СУДЛАЛЫН
ХҮРЭЭЛЭНГИЙН АСПИРАНТ П.ЧҮЛТЭМСҮРЭНГИЙН “XVII ЗУУНЫ ТҮҮХЭН ДЭХ ЦОГТ ХУНТАЙЖ
(1581-1637)” АВТОРЕФЕРАТАД ӨГӨХ ШҮҮМЖ

2022.03.14

Улаанбаатар хот

Оросын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Буддын шашин, Төвөд судлалын хүрээлэнгийн аспирант П.Чүлтэмсүрэнгийн “XVII зууны түүхэн дэх Цогт хунтайж (1581-1637)” диссертаци удиртгал, хоёр бүлэг, найман зүйл, дүгнэлт, ном зүй, хавсралт бүхий 197 тал хуудас болсон нь техникийн шаардлага хангаж байна.

“Цогт хунтайж болон түүний үр хойчсын намтар” гэх тэргүүн бүлэг 4 зүйлтэй. Эхний зүйлд Цогт хунтайжийн амьдрал, үйл ажиллагааны түүхийн тухай өгүүлдэг үндсэн сурвалжийн талаар, 2-р зүйлд судалгааны сэдвийн түүх бичлэгийг өгүүлжээ. 3-р зүйлд Цогт хунтайжийн намтар, 4-р зүйлд Монгол улс дахь Цогт хунтайжийн үр хойчис, 5-р зүйлд Буриад дахь Цогт хунтайжийн үр хойчисын тухай бичсэн байна.

“Монголын түүх, соёлд Халхын Цогт хунтайжийн үүрэг, ач холбогдол” гэх дэд бүлэг 3 зүйлтэй юм байна. Эхний зүйлд XVII зууны Халхын түүхэн нөхцөл байдлыг өгүүлсэн байна. 2-р зүйлд Цогт хунтайжийн улс төрийн үйл ажиллагааг бичсэн бол 3-р зүйлд Монголын түүх, соёлд Цогт хунтайжийн үүргийг авч үзсэн байна.

Аспирант П.Чүлтэмсүрэн бээр Монголын түүхэнд багагүй судлагдсан Цогт хунтайжийн намтар, үйл ажиллагааг дахин шинэлэг байдлаар авч үзэхийг оролдсон байна. Буриадад байгаа Цогт хунтайжийн үр хойчисын талаар тусгай зүйл болгон өгүүлснийг сайшаан тэмдэглэж байна.

Төгсгөлд нь тэмдэглэхэд, Оросын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Буддын шашин, Төвөд судлалын хүрээлэнгийн аспирант П.Чүлтэмсүрэнгийн “XVII зууны түүхэн дэх Цогт хунтайж (1581-1637)” диссертаци докторын зэрэг горилох шаардлага хангасан ажил болсон гэж үзэж байна.

ШҮҮМЖ БИЧСЭН



ПРОФЕССОР Ж.ГЭРЭЛБАДРАХ
МУБИС-ИЙН ТҮҮХИЙН ТЭНХИМИЙН ЭРХЛЭГЧ